



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

“ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА,
ТУРШИЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, БИЗНЕСИЙН
АРМОНО КОРПОРАЦИ” ТӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.ЦАГААНХҮҮ
ТАНАА

2017.03.15 № 3/462
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн Армоно корпораци” ТӨААТҮГ-ын гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн Армоно корпораци” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн Армоно корпораци" ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН “АРМОНО КОРПОРАЦИ” ТӨҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663,
Цахим хаяг:

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 99102115
Цахим хаяг:
sambuunyamya@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ганбилэг
Утас: 261885, 91017006
Цахим хаяг:
ganbilegd@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 3 дугаар сарын 13

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн “Армоно корпораци” ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2017/35/-СТА-ТӨҮГ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн “Армоно корпораци” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Армоно корпораци” ТӨҮГ-ын удирдлага нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн “Армоно корпораци” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 9 дүгээр сарын 26-ны өдрөөс 10 дугаар сарын 26-ны хооронд нэг сарын хугацаагаар завсрын аудитаар үзэж шалган Менежментийн захидал бичиж зөвлөгөө өгч зарим дутагдлыг арилгах шаардлага тавьж хэрэгжүүлсэн. 2017 оны 2 дугаар сарын 20-ноос 2017 оны 3 дугаар сарын 05-ны хооронд хийхээр төлөвлөж 2017 оны 2 дугаар сарын 15-наас 2017 оны 3 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэв. /ТАБ-СТА-А-10/

Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн “Армоно корпораци” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 3 дугаар сарын 15-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2017 оны 3 дугаар сарын 13-наас 2017 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хянаж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 16-нд Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн “Армоно корпораци” ТӨҮГ-ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн “Армоно корпораци” ТӨҮГ-ын төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Компанийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт доорхи өөрчлөлт байна.

Монгол улсын Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 02-ны тогтоол 78-ын 3 дугаарт “Эрдэм шинжилгээний байгууллагуудын үндсэн хөрөнгө дэд бүтцийг хэвээр хадгалан чиг үүргийн дагуу ашиглуулах, хөнгөн үйлдвэрийн судалгаа туршилт үйлдвэрлэл, бизнесийн корпорацийг БСШУ-ны яамны харъяа хөнгөн үйлдвэрийн судалгаа туршилт үйлдвэрлэл бизнесийн корпорацийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулсугай” гэсэн заалтын дагуу аж ахуйн тооцоотой үйл ажиллагаа явуулах болсон.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Армоно корпораци” ТӨҮГ нь Улаанбаатар хотын Хан-уул дүүрэгт “Хөнгөн үйлдвэрийн салбарт био нано өндөр технологи болон инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, дамжуулах тус салбарт эрдэм шинжилгээ судалгаа туршилт зохион бүтээх ажил, зөвлөх үйлчилгээг үзүүлэх, мэргэжлийн хүний нөөц бэлтгэх, сургалт зохион байгуулах” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Арьс шир, үслэг боловсруулах байгаль орчинд халгүй технологийн судалгааг нутагшуулах.
- Жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж болон хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах, зөвлөх үйлчилгээ.
- Арьс ширний салбарын стандарт боловсруулах, батлуулах.
- Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ.
- Арьс шир, үслэг боловсруулах үслэг боловсруулах үйлдвэрүүдийн химийн болон туслах материалын судалгаа, сонголт.
- Арьс шир үслэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
- Мэргэжлийн инженер техникийн ажилтнуудын сургалт явуулах зэрэг болно.

Инновацийн ба грант төслүүдийн хэрэгжиж байна. Үүнд:

1. 2016 - 2019 онд **“Арьс шир боловсруулах технологид цэвэр ус хэмнэх технологийн оновчтой шийдэл” ШУТС-гийн төсөл.** 2016 оны 3 дугаар сараас 2019 оны 3 дугаар сард багтаахаар гэрээнд заасан байна.
2. 2016 - 2018 онд **“Бөсгөсөн шохой- инновацийн бүтээгдэхүүн технологийн нэвтрүүлэлт” Инновацийн төсөл.** 2016 оны 5 дугаар сараас 2018 оны 12 дугаар сард багтаахаар гэрээнд заасан байна.

3. 2016 - 2018 онд **“Чихрийн шижинтэй хүнд зориулсан тусгай зориулалтын гутлын хэвлүүрийн зохион бүтээлт, технологийн нэвтрүүлэлт” Инновацийн төсөл.** 2016 оны 5 дугаар сараас 2018 оны 12 дугаар сард багтаахаар гэрээнд заасан байна.

4. 2014 - 2016 онд **“Импортыг орлох ажлын гутлын зориулалттай ус нэвтэрдэггүй арьс боловсруулах технологи, нэвтрүүлэлт” ШУТС-гийн төсөл.** 2014 оноос 2016 онд багтаахаар гэрээнд заасан байна.

Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн “Армоно корпораци” ТӨҮГ-ын төсвөөс санхүүжилт авдаггүй үндсэн үйл ажиллагааны орлого болох арьс шир боловсруулах болон итгэмжлэгдсэн лабораторын шинжилгээний орлого, төсөл хөтөлбөрийн орлого, ажлын байрны сул чөлөөтэй талбай түрээслүүлсний орлогоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийт орлогын **76,8%** нь түрээсийн орлого, **5,3%** нь арьс шир боловсруулах болон шинжилгээний орлого, **17.9%** нь төсөл хөтөлбөрийн орлого байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн “Армоно корпораци” ТӨҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, УСНББУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн “Армоно корпораци” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд балансын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 18-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн “Армоно корпораци” ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад, санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг “Баталгаа аудит” ХХК-ийн аудитуудын туслалцааг авч шинээр боловсруулан 2016 оны 12 дугаар сарын 01-нээс эхлэн мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС-тай нийцсэн байна. СТОУС-

ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

“Армоно корпораци” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд” бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Армоно корпораци” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Povor cort” санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдал:

Материаллаг байдлыг тооцохдоо 2016 оны 12 дугаар сарын 31-нээрх нийт зардлыг суурь болгон дундаж хувь болох 2 хувиар буюу 7.2 сая төгрөгөөр тогтоолоо.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Армоно корпораци” ТӨҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед **бага** гэж тооцсон ба аудитын гүйцэтгэлийн шатанд дотоод хяналтын шалгалтыг үндсэн үйл ажиллагааны стандартад нийцэж байгааг тодорхойлох зорилгоор гүйцэтгэхэд дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

“Армоно корпораци” ТӨҮГ-ын 2016 оны жилийн санхүүгийн орлого үр дүнгийн тайлангаар 340.7 сая төгрөгийн орлоготой тайлагнасан байна.

Үүнд:Түрээсийн орлого 261.6 сая төгрөг буюу нийт орлогын 76.8%, арьс шир боловсруулах, шинжилгээний орлого болон бусад орлого 18.2 сая төгрөг буюу 5.3%, төсөл хөтөлбөрийн орлого 60.9 сая төгрөг буюу 17.9%-ийг эзэлж байна.

Жилийн санхүүгийн орлого үр дүнгийн тайлангаар 358.7 сая төгрөгийн зардал тайлагнасан ба санхүүгийн үр дүн 63.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. Нийт зардлын дүнд цалин, шимтгэлийн зардал 160.7 сая төгрөг буюу 44.8%, халаалт, цахилгааны зардал 60.1 сая төгрөг буюу 16.8%, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 87.5 сая төгрөг буюу 24.4%, бусад зардал 50.4 буюу 14.1%, төсөлт ажлын зардал 42.8 буюу 11.9%-ийг тус тус эзэлж байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих

мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангах зорилгоор 5 сая төгрөгөөс дээш дүнтэй ажил гүйлгээг танилцуулга самбар дээр бичиж өөрийн вэб сайтад байршуулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 10 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагавар

1. НББ-ийн Бодлогын баримт бичиг боловсруулж 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн.
2. Үндсэн хөрөнгийн тайлант хугацааны элэгдлийн тооцоолол зөв хийгдэж холбогдох дансдын бичилт үнэн бөгөөд хөрөнгийг зардалд бичсэн зөрчил дутагдал гаргаагүй байна.
3. Өмнөх жилийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг аудитын зөвлөгөө шаардлагын дагуу арилгаж үр дүнтэй ажилласан үнэлгээ өгөхүйц хэмжээнд хүрчээ.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

“Армоно корпораци” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, авлага өглөг, бараа материал, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 100 хувь, мөнгөн хөрөнгийн 80 хувь, нийт зардлын 75 хувь, нийт хөрөнгийн 80 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэж “Менежментийн захидал”-д тодорхой тусгав. Үүнд:

1. Анхан шатны бүртгэлийн баримт /бараа материал, түүхий эд материал/-ууд гарын үсэг тамга тэмдэггүй байгааг онцгой анхаарвал зохино.
2. Бензин шатахууны зарцуулга авто машины гүйлтийн нормоос илүү гарч зардалд бичигдэж тайлагнагдсан байгааг анхааралдаа авч жолооч нар хувийн ашиг сонирхлоор хандсан тохиолдол байхыг үгүйсгэхгүй. Ийм учир гүйцэтгэсэн ажилд гүйлтийн зам хэмжээ, шатахуун зарцуулалтын нормын хяналтыг тогтмол баримталбал зохино.

Шийдвэрлэсэн нь: Эдгээр зөрчил дутагдлуудтай холбогдох хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэх шаардлага тавьсан.

НӨАТ-ын шинэчилсэн журмын дагуу санхүүгийн тайланд БМҮБЗүйлийн худалдах, худалдан авах ажиллагааг бүртгэл тооцоогоор үнэн зөв тусгавал зохино.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх .

Анхан шатны бүртгэлийн баримтжуулахыг албан ёсны /албажуулж/ болгож эд хариуцагчдын тайланд тусгах журмыг ягштал мөрдөх хэрэгтэй.

Шийдвэрлэсэн нь: Аудитын менежментийн захидлаар зөвлөгөө өгч шаардлага тавив.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна

Материаллаг бус зөрчил энэ удаагийн аудитын явцад илэрсэнгүй.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдаагүй алдаа гараагүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Байхгүй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн “Армоно корпораци” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 117.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 87.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 2.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 28.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Баталгаа Аудит” ХХК гүйцэтгэж Зөрчилгүй санал дүгнэлт өгсөн ба уг аудитаар 10 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 90 хувийг хэрэгжүүлж, 10 хувийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн “Армоно корпораци” ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал,

санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, тодруулга хавсралтууд 14 хуудас, байгууллагын тайлагнал санал 5 хуудсыг тус тус хавсаргав.



ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН “АРМОНО КОРПОРАЦИ” ТӨҮГ- ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1

Анхан шатны бүтгэлийн баримтуудыг
албажуулах талаар 3

Асуудал 2

Шатахууны зардлын тооцооны
талаар..... 4

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН “АРМОНО КОРПОРАЦИ” ТӨҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН “АРМОНО КОРПОРАЦИ” ТӨҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Анхан шатны баримтуудыг албажуулах талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
--	---

Ажиглалт

Эд хариуцагчдын тайланд тусгагдсан бараа материал, эд хогшлын орлого зарлагын баримтууд гарын үсэг, тэмдгээр албажиж батлагдаагүй байна.

Зөвлөмжүүд

Гүйцэтгэсэн ажил үйлчилгээг анхан шатны баримтаар нягтлан бодох бүртгэлд тусган авч тооцоог бодох. Энэ нь НББ-д анхан шатны бүртгэлийн баримтжуулалтыг иж бүрэн гүйцэтгэх Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар заалт, “Анхан шатны бүртгэлийн баримтыг нөхөх заавар” зэргийг бүрэн хэрэгжүүлбэл зохино .

Эрсдэлүүд

1. Бүрдүүлсэн баримтууд албан ёсны гарын үсэг тэмдэггүйгээр тайланд тусгагдсанаар тайлан баланс буруу гарах
2. Хөрөнгө мөнгийг үр ашиггүй зарцуулах, бусдад завших бололцоо олгох
3. Орлого болон зарлагыг албан ёсны бус баримтаар илэрхийлэх нь хөрөнгө завших, үнэн зөв иж бүрэн байх, нягтлан бодох бүртгэлийн нийтлэг зарчмыг зөрчинө.

ТӨҮГ-ын удирдлагын хариу

“Армоно корпораци” ТӨҮГ-ын нягтлан бодогч М.Наранцэцэг өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр зөвшөөрсөн.

Асуудал 2: Шатахууны зардлын тооцооны талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

Ажиглалт

Автомашинд зарцуулсан бензиний зарлага явсан км, нормын дагуу тооцоо бодоогүйгээс 1.2 сая төгрөгийн зардал тайланд илүү тусгагдсан.

Зөвлөмж

Анхан шатны баримтуудыг худалдах худалдан авах ажиллагааны явцад бодитой үнэн зөв бүрдүүлэх ёстой. Ялангуяа НӨАТ-ын тухай ГТЕГ-ын 2016 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн А-21 тоот тушаалын нэгдүгээр хавсралтанд заагдсан борлуулсан, бараа үзүүлсэн ажил үйлчилгээний тооцоог баримтлах

Эрсдэлүүд

И-баримт /Е-barimt/-ыг автомашины гүйлт, бензин зарцуулалтын нормтой тулгаж хяналт шалгалт хийхгүй нөхцөлд

1. Хөрөнгийн илүү зарцуулалт гарч үр ашиггүй ажиллагаанд нөлөөлнө.
2. Жолооч нарын хувийн ашиг сонирхолын нөлөөгөөр байгууллагын үйл ажиллагааны үр дүн материаллаг бус байдлаар алдагдах сөрөг нөлөө үзүүлнэ.

ТӨҮГ-ын удирдлагын хариу

“Армоно корпораци” ТӨҮГ-ын нягтлан бодогч М.Наранцэцэг өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр зөвшөөрсөн.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

СТ-1

" АРМОНО КОРПОРАЦИ" ХХК

12/31/2016

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

/төгрөгөөр/

Балансын зүйл	Үлдэгдэл	
	1 дүгээр сарын 1	12 сарын 31
1. Хөрөнгө		
1.1 Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	43,637.52	11,471,516.38
Дансны авлага	24,433,995.00	27,852,225.00
Татвар, НДШ-ийн авлага	-	-
Бусад авлага	-	110,000.00
Бараа материал	7,955,304.28	4,136,295.34
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	19,891,518.90	22,637,458.66
<u>Эргэлтийн хөрөнгийн дүн</u>	<u>52,324,455.70</u>	<u>66,207,495.38</u>
1.2 Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,281,557,300.10	1,232,044,394.45
Биет бус хөрөнгө	1,090,045.17	980,540.61
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
<u>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</u>	<u>1,282,647,345.27</u>	<u>1,233,024,935.06</u>
<u>1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u>	<u>1,334,971,800.97</u>	<u>1,299,232,430.44</u>
2.Өр төлбөр ба эздийн өмч		
2.1 Өр төлбөр		
2.1.1 Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	53,790,304.64	45,172,000.95
Цалингийн өглөг	4,206,202.00	18,607.91
Татварын өр	50,406,726.35	47,069,251.17
НДШ-ийн өглөг	13,292,588.96	3,703,074.23
Богино хугацаат зээл	-	-
Урьдчилж орсон орлого	39,060,000.00	71,775,000.00
<u>Богино хугацаат өр төлбөрийн дүн</u>	<u>160,755,821.95</u>	<u>167,737,934.26</u>
2.1.2 Урт хугацаат өр төлбөр		
<u>Урт хугацаат өр төлбөрийн дүн</u>	<u>-</u>	<u>-</u>
<u>Өр төлбөрийн нийт дүн</u>	<u>160,755,821.95</u>	<u>167,737,934.26</u>
2.3 Эздийн өмч		
Өмч: - төрийн	122,037,243.10	122,037,243.10
- хувийн	-	-
Нэмж төлөгдсөн капитал	1,956,489,370.00	1,977,140,151.25
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Эздийн өмчийн бусад хэсэг	100,931,461.00	100,931,461.00
Хуримтлагдсан ашиг	(1,005,242,095.08)	(1,068,614,359.17)
<u>Эздийн өмчийн дүн</u>	<u>1,174,215,979.02</u>	<u>1,131,494,496.18</u>
<u>2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</u>	<u>1,334,971,800.97</u>	<u>1,299,232,430.44</u>

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

СТ-2

" АРМОНО КОРПОРАЦИ" ХХК

12/31/2016

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
<u>1. Борлуулалтын орлого /цэвэр/</u>	<u>57,333,327.89</u>	<u>75,598,402.70</u>
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	58,494,982.03	42,877,062.41
<u>3. Нийт ашиг</u>	<u>(1,161,654.14)</u>	<u>32,721,340.29</u>
4. Түрээсийн орлого	241,091,120.67	261,633,776.94
5. Хүүний орлого	-	-
6. Ногдол ашгийн орлого	-	-
7. Эрхийн шимтгэлийн орлого		
8. Бусад орлого	1,833,829.00	3,512,320.00
9. Борлуулалт, маркетингийн зардал		
10. Ерөнхий ба удирдлагын зардал	344,099,931.11	358,745,478.59
11. Санхүүгийн зардал		
12. Бусад зардал	260,000.00	2,494,222.73
13. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-
14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
17. Бусад ашиг (алдагдал)	-	-
<u>18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</u>	<u>(102,596,635.58)</u>	<u>(63,372,264.09)</u>
19. Орлогын татварын зардал	-	
<u>20. Татварын дараах ашиг (алдагдал)</u>	<u>(102,596,635.58)</u>	<u>(63,372,264.09)</u>
<u>21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) /шалгалтын акт/</u>		
<u>22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</u>	<u>(102,596,635.58)</u>	<u>(63,372,264.09)</u>
<u>23. Бусад дэлгэрэнгүй орлого</u>		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
<u>24. Орлогын нийт дүн</u>		
<u>25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</u>		

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

" АРМОНО КОРПОРАЦИ" ХХК

12/31/2016

СТ-3

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 01 дүгээр сарын 01	122,037,243.10		388,202,561.00	1,669,218,270.00		-	(1,004,242,095.08)	1,175,215,979.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							(1,000,000.00)	(1,000,000.00)
Залруулсан үлдэгдэл	-					-		-
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/								-
Өмчид гарсан өөрчлөлт								-
Зарласан ногдол ашиг								-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
2015 оны 12 дугаар сарын 31	122,037,243.10		388,202,561.00	1,669,218,270.00	-	-	(1,005,242,095.08)	1,174,215,979.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								-
Залруулсан үлдэгдэл				-	-	-		-
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/							(63,372,264.09)	(63,372,264.09)
Бусад дэлгэрэнгүй орлого								-
Өмчид гарсан өөрчлөлт			20,650,781.25					20,650,781.25
Зарласан ногдол ашиг								
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
2016 оны 12 дугаар сарын 31	122,037,243.10	-	408,853,342.25	1,669,218,270.00	-	-	(1,068,614,359.17)	1,131,494,496.18

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

СТ-4

" АРМОНО КОРПОРАЦИ" ХХК

12/31/2016

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

/төгрөгөөр/

	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1. Мөнгөн орлогын дүн	258,922,660.00	368,330,455.00
1.2. Мөнгөн зарлагын дүн	297,039,622.93	356,748,376.14
1.3. Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(38,116,962.93)	11,582,078.86
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1. Мөнгөн орлогын дүн	-	-
2.2. Мөнгөн зарлагын дүн	1,785,100.00	154,200.00
2.3. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,785,100.00)	(154,200.00)
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1. Мөнгөн орлогын дүн	39,800,000.00	-
3.2. Мөнгөн зарлагын дүн	-	-
3.3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	39,800,000.00	-
4. Валютын ханшийн зөрүү		-
5. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(102,062.93)	11,427,878.86
6. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	145,700.45	43,637.52
7. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	43,637.52	11,471,516.38